

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг	MNS 5029 : 2011
Occupational safety and health. Label and marking of toxic and hazardous chemicals	MNS 5029 : 2001-ийн оронд

Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 27- ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй,

Энэ стандартын бүх шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

1.1 Энэхүү стандартаар химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодлын шошго болон түүнийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл, хадгалах агуулах, ашиглах ажлын байрны анхааруулах тэмдэгт тавигдах ерөнхий шаардлагыг тогтооно.

1.2 Импортын химийн бодис дээрх үйлдвэрлэгчийн шошгонд энэхүү стандарт хамаарахгүй байж болно.

1.3 Үйлдвэрлэсэн болон жижиглэн савлаж борлуулж буй химийн бодист энэхүү стандартыг заавал мөрдөнө.

2 Норматив ишлэл

2.1 НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан заавар”, НҮБ, 2003

2.2 “Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем”, НҮБ, 2003

2.3 Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 04/04 дугаар хамтарсан тушаал

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

химийн хорт бодис

хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдэл;

3.2

Химийн аюултай бодис

тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдэл;

3.3

шошго

химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн агуулсан сав баглаа дээр тавигддаг, эсвэл сав, баглаа боодолд бэхлэгддэг, тухайн хортой, аюултай бүтээгдэхүүний талаар бичмэл болон дүрс хэлбэрээр илэрхийлсэн мэдээлэл;

3.4

химийн нэршил

шинжлэх ухааны хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, Онолын болон хавсарга химийн олон улсын холбоо (IUPAC) ба Химийн асуудлаар тойм бэлтгэх алба (CAS) –аас гаргасан нэршил;

3.5

худалдааны нэршил

шинжлэх ухааны хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, Онолын болон хавсарга химийн олон улсын холбоо ба Химийн асуудлаар тойм бэлтгэх албаас гаргасан нэршлээс гадна ихэвчлэн худалдаа, дүрэм, журам, хууль эрхийн актуудад бодис, хольцыг тодорхойлоход ашигладаг нэршил;

3.6

НҮБ-ын дугаар (UN number)

олон улсын тээвэрлэлтэд ашиглах зорилгоор химийн хорт болон аюултай бодисыг дугаарласан 4 оронтой тоо. Ижил шинж чанартай бүлэг бодисыг нэг дугаараар дугаарласан байж болно;

3.7

олон улсын бүртгэлийн дугаар (cas number)

химийн элемент, нэгдэл, полимер, микроорганизм, хольц болон хайлшийг Химийн асуудлаар тойм бэлтгэх албанаас (CAS) бүртгэж дугаарласан дугаар;

3.8

анхааруулах тэмдэг

ямар нэг хор аюулын талаархи мэдээллийг хамгийн товч байдлаар дамжуулах график дүрслэл;

3.9

дохио үг

болзолт аюулын тухай урьдчилан анхааруулах, хор, аюулын ноцтой байдлын харьцангуй түвшинг заах зорилгоор хэрэглэдэг үг. Жишээлбэл: “Аюултай”, “Болгоомжил” гэх мэт;

3.10

аюулын тэмдэглэгээ

тухайн аюултай бүтээгдэхүүний хор аюулын шинж чанар, аюулын түвшинг илэрхийлсэн хэллэг.

жишээлбэл: “Халаавал шатах аюултай”, “Хавдар үүсгэнэ” гэх мэт.

4 Анхааруулах тэмдгийн хэлбэр

Анхааруулах тэмдэг нь өнцөг дээр нь босгосон шоо дөрвөлжин хэлбэртэй байна.

5 Анхааруулах тэмдгийн хэмжээ, байршил

Анхааруулах тэмдэг нь төрлөөсөө хамаарч дараах хэмжээтэй байх ба 1-р хүснэгтэд заасан байршилд байрлуулсан байна.

1 -р хүснэгт- Анхааруулах тэмдгийн хэмжээ, байршил

Анхааруулах тэмдгийн төрөл	Анхааруулах тэмдгийн хэмжээ, мм	Байршил
Тээврийн хэрэгслэлд	250 х 250 мм буюу түүнээс дээш	1.Төмөр замын вагон/цистерн, чингэлэгийн 2 хажуу тал дээр; 2.Автотээврийн хэрэгслэлийн 2 хажуу тал болон ар тал дээр; 3.Анхааруулах тэмдэг байрлуулах хангалттай гадаргуугүй тээврийн хэрэгслэлийн хувьд тээвэрлэж буй ачаан дээр харагдахуйцаар ил байрлуулсан байна.
Агуулах, ажлын байранд	250 х 250 мм буюу түүнээс дээш (10 м-ийн зайнаас уншигдах боломжтой байх)	1.Бодис ашиглаж буй ажлын байрны дотор хана; 2. Хадгалж буй агуулахын гадна ба дотор хана;
5 л эсвэл 5 кг-аас их хэмжээгээр савлагдсан сав, баглаа боодолд	100 х 100 мм буюу түүнээс дээш	1. Сав, баглаа боодол бүр дээр; 2. 450л эсвэл 450 кг-аас ихээр савлагдсан сав, баглаа боодлын эсрэг 2 тал дээр
5 л эсвэл 5 кг-аас бага хэмжээгээр савлагдсан сав,баглаа боодолд	100 х 100 мм буюу түүнээс доош байж болно	Сав,баглаа боодол бүр дээр

6 Анхааруулах тэмдгийн дүрслэл, өнгө

Химийн хорт болон аюултай бодисын дэд ангилал бүрээр аюул ослыг анхааруулсан тодорхой өнгөөр дүрслэгдсэн анхааруулах тэмдэгтэй байна.

2-р хүснэгт- Анхааруулах тэмдгийн дүрслэл, өнгө

Ангилал	Тэсрэмтгий бодис						Исэлдүүлдэгч			Идэмхий
Дэд ангилал	Тэсрэмтгий бодис	1.2 Цохилтын хүч үүсгэх аюултай	1.3 Галын болон бага хэмжээгээр тэсрэх, цохилтын хүч үүсгэх аюултай	1.4 Бага хэмжээний галын болон тэсрэх/ цохилтын хүч үүсгэх аюултай	1.5 Өдөөлтийн дараа онцгой тэсрэмтгий	1.6 Өдөөлтийн дараа тэсрэмтгий	5.1.1 Исэлдүүлэгч шингэн ба хатуу бодис, органик хэт исэл	5.1.2 Исэлдүүлэгч хий	5.2 Органик хэт исэл	8.1 Металл зэврүүлэгч
Сав боодол болон агуулах, ажлын байранд	Аюулын тэмдэглэгээ (тэсэрч буй бөмбөг): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (тэсэрч буй бөмбөг): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (тэсэрч буй бөмбөг): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ (тойрог дээрх дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (тойрог дээрх дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан

Тээврийн чингэлэг, автотээврийн хэрэгсэл, төмөр замын вагон/цистернт	Аюулын тэмдэглэгээ (тэсэрч буй бөмбөг): хар, Дэвсгэр: улбар шар, Доод өнцөгт "1" тоо	Аюулын тэмдэглэгээ (тэсэрч буй бөмбөг): хар, Дэвсгэр: улбар шар, Доод өнцөгт "1" тоо	Аюулын тэмдэглэгээ (тэсэрч буй бөмбөг): хар, Дэвсгэр: улбар шар, Доод өнцөгт "1" тоо	Дэвсгэр: улбар шар, Тоо: 5 мм өргөн, 30 мм өндөртэй "1.4" гэсэн тоо (100 х100 мм-ийн анхааруулах тэмдгийн хувьд), Доод өнцөгт "1" тоо	Дэвсгэр: улбар шар, Тоо: 5 мм өргөн, 30 мм өндөртэй "1.5" гэсэн тоо (100 х100 мм-ийн анхааруулах тэмдгийн хувьд), Доод өнцөгт "1" тоо	Дэвсгэр: улбар шар, Тоо: 5 мм өргөн, 30 мм өндөртэй "1.6" гэсэн тоо (100 х100 мм-ийн анхааруулах тэмдгийн хувьд), Доод өнцөгт "1" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: шар, Доод өнцөгт "5.1" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: шар, Доод өнцөгт "5.1" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: шар, Доод өнцөгт "5.1" тоо	Аюулын тэмдэглэгээ (металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн): хар, Дэвсгэр: доод хэсэг нь хар,дээд хэсэг нь цагаан, Доод өнцөгт "8" тоо
--	--	--	--	---	---	---	--	--	--	--

3-р хүснэгт- Анхааруулах тэмдгийн дүрслэл, өнгө

Ангилал	Шатамхай									
Дэд ангилал	2.1.1 Шатамхай хий	2.1.2 Шатамхай аэрозоль	3.1 Шатамхай шингэн	3.2 Сулруулсан шингэн тэсрэх бодис	4.1.1 Шатамхай хатуу бодис	4.1.2 Өөрөө идэвхждэг шатамхай хатуу бодис	4.1.3 Сулруулсан хатуу тэсрэх бодис	4.2 Агаарт өөрөө шатамхай	4.3 Норговол шатамхай	
Сав, баглаа боодол болон агуулах, ажлын байранд	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (тойрог дээрх дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан

Аюултай ачаа тээвэрлэгч тээврийн хэрэгсэлд	Аюулын тэмдэг-лэгээ (дөл): хар эсвэл цагаан, Дэвсгэр: улаан, Доод өнцөгт "2" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар эсвэл цагаан, Дэвсгэр: улаан, Доод өнцөгт "2" тоо	Аюулын тэмдэг-лэгээ (дөл): хар эсвэл цагаан, Дэвсгэр: улаан, Доод өнцөгт "3" тоо	Аюулын тэмдэг-лэгээ (дөл): хар эсвэл цагаан, Дэвсгэр: улаан, Доод өнцөгт "3" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: 7 улаан босоо зураас бүхий цагаан, Доод өнцөгт "4" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: 7 улаан босоо зураас бүхий цагаан, Доод өнцөгт "4" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: 7 улаан босоо зураас бүхий цагаан, Доод өнцөгт "4" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар, Дэвсгэр: доод хэсэг нь улаан, дээд хэсэг нь цагаан, Доод өнцөгт "4" тоо	Аюулын тэмдэглэгээ (дөл): хар эсвэл цагаан, Дэвсгэр: цэнхэр, Доод өнцөгт "4" тоо
--	--	---	--	--	--	--	--	--	--

4 -р хүснэгт- Анхааруулах тэмдгийн дүрслэл, өнгө

Ангилал	Хортой							
Дэд ангилал	6.1 Онцгой хортой	6.3 Арьс үрэвсүүлэгч	6.4 Нүд үрэвсүүлэгч	6.5 Харшил өдөөгч	6.6 Үр удамд нөлөөлөгч	6.7 Хавдар үүсгэгч	6.8 Нөхөн үржихүй/ өсөлт хөгжилтөнд нөлөөлөгч	6.9 Тодорхой эрхтэн системийг хордуулагч
Сав, баглаа боодол болон агуулах, ажлын байранд	Аюулын тэмдэг-лэгээ (Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэг лэгээ (Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Хүний дүрс): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Хүний дүрс): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Хүний дүрс): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Хүний дүрс): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Хүний дүрс): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан
Аюултай ачаа тээвэрлэгч тээврийн хэрэгсэлд	Аюулын тэмдэг-лэгээ (Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс): хар, Дэвсгэр: цагаан, Доод өнцөгт "6" тоо	Аюулын тэмдэг-лэгээ (Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс): хар, Дэвсгэр: цагаан, Доод өнцөгт "6" тоо	Аюулын тэмдэглэгээ (Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс): хар, Дэвсгэр: цагаан, Доод өнцөгт "6" тоо	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй

5-р хүснэгт- Анхааруулах тэмдгийн дүрслэл, өнгө

Ангилал	Идэмхий		Байгаль орчинд хортой			
Дэд ангилал	8.2 Арьс гэмтээгч	8.3 Нүд гэмтээгч	9.1 Усны амьд организмд хортой	9.2 Хөрсний амьд организмд хортой	9.3 Сээр нуруутан амьтанд хортой	9.4 Сээр нуруугүй амьтанд хортой
Сав, баглаа боодол болон агуулах, ажлын байранд	Аюулын тэмдэглэгээ (Металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Загас ба мод): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Загас ба мод): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Загас ба мод): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан	Аюулын тэмдэглэгээ (Загас ба мод): хар, Дэвсгэр: цагаан, Хүрээ: улаан
Аюултай ачаа тээвэрлэгч тээврийн хэрэгсэлд	Аюулын тэмдэглэгээ (металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн): хар, Дэвсгэр: доод хэсэг нь хар,дээд хэсэг нь цагаан, Доод өнцөгт “8” тоо	Аюулын тэмдэглэгээ (металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн): хар, Дэвсгэр: доод хэсэг нь хар,дээд хэсэг нь цагаан, Доод өнцөгт “8” тоо	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй	Аюулын тэмдэглэгээ шаарддаггүй

7 Тэмдэг, шошгоны бүрдэл хэсэг

Химийн хорт болон аюултай бодисын дэд ангилал бүрээр аюул ослыг анхааруулсан анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээтэй байна.

6-р хүснэгт- Тэмдэг, шошгоны элемент

Ангилал		Тэсрэмтгий бодис						Исэлдүүлдэгч			Идэмхий
Дэд ангилал		1.1 Онцгой тэсрэмтгий	1.2 Цохилтын хүч үүсгэх аюултай	1.3 Галын болон бага хэмжээгээр тэсрэх, цохилтын хүч үүсгэх аюултай	1.4 Бага хэмжээний галын болон тэсрэх/ цохилтын хүч үүсгэх аюултай	1.5 Өдөөлтийн дараа онцгой тэсрэмтгий	1.6 Өдөөлтийн дараа тэсрэмтгий	5.1.1 Исэлдүүлэгч шингэн ба хатуу бодис	5.1.2 Исэлдүүлэгч хий	5.2 Органик хэт исэл	8.1 Металл зэврүүлэгч
Сав, баглаа боодол (дотоод савалгаа) болон агуулах, ажлын байранд	Анхааруулах тэмдэг				-	-	-				
	Дохио үг	Аюултай	Аюултай	Аюултай	Болоомжил	Болоомжил	-	Аюултай	Аюултай	Аюултай	Болгоомжил
	Аюулын тэмдэглэгээ	Онцгой тэсрэмтгий	Тэсрэмтгий бодис; Цохилтын хүч үүсгэх аюултай	Галын болон бага хэмжээгээр тэсрэх, цохилтын хүч үүсгэх аюултай	Бага хэмжээний галын болон тэсрэх/ цохилтын хүч үүсгэх аюултай	Өдөөлтийн дараа онцгой тэсрэмтгий	-	Шатах, тэсрэх аюултай, хүчтэй исэлдүүлэгч	Гал гаргах буюу галыг тэтгэх чадвартай; исэлдүүлэгч	Халвал шатах аюултай	Металлыг зэврээнэ
Тээврийн чингэлэг, автотээврийн хэрэгсэл, төмөр замын вагон/цистерн болон гадаад савалгаанд											









7-р хүснэгт- Тэмдэг, шошгоны элемент

Ангилал		Шатамхай								
Дэд ангилал		2.1.1 Шатамхай хий	2.1.2 Шатамхай аэрозоль	3.1 Шатамхай шингэн	3.2 Сулруулсан шингэн тэсрэх бодис	4.1.1 Шатамхай хатуу бодис	4.1.2 Өөрөө идэвхждэг шатамхай хатуу бодис	4.1.3 Сулруулсан хатуу тэсрэх бодис	4.2 Агаарт өөрөө шатамхай	4.3 Норговол шатамхай
Сав, баглаа боодол болон агуулах, ажлын байранд	Анхааруула х тэмдэг									
	Дохио үг	Аюултай	Аюултай	Аюултай	Болгоомжил	Аюултай	Аюултай	Болгоомжил	Аюултай	Аюултай
	Аюулын тэмдэглэгээ	Галын онцгой аюултай хий	Галын онцгой аюултай аэрозол	Онцгой шатамхай шингэн ба уур	Шатамхай шингэн ба уур	Шатамхай хатуу бодис	Өөрөө идэвхжиж шатна	Шатамхай хатуу бодис	Агаарт ил гарвал өөрөө шатна	Норговол шатамхай
Аюултай ачаа тээвэрлэгч тээврийн хэрэгсэлд										

8-р хүснэгт- Тэмдэг, шошгоны элемент

Ангилал		Хортой							
Дэд ангилал		6.1 Онцгой хортой	6.3 Арьс үрэвсүүлэгч	6.4 Нүд үрэвсүүлэгч	6.5 Харшил өдөөгч	6.6 Үр удамд нөлөөлөгч	6.7 Хавдар үүсгэгч	6.8 Нөхөн үржихүй/ өсөлт хөгжилтөнд нөлөөлөгч	6.9 Тодорхой эрхтэн системийг хордуулагч
Сав, баглаа боодол болон агуулах, ажлын байранд	Анхааруулах тэмдэг								
	Дохио үг	Хортой	Хортой	Хортой	Хортой	Хортой	Хортой	Хортой	Хортой
	Аюулын тэмдэглэгээ	Залгивал үхэлд хүргэнэ	Арьсанд хүрвэл үрэвсүүлнэ	Нүдэнд орвол үрэвсүүлнэ	Харшил үүсэх, амьсгал боогдуулах аюултай	Үр удамд нөлөөлнө	Хавдар үүсгэнэ	Үржлийн эрхтэн болон урагт нөлөөлнө	Эрхтэн системийг гэмтээнэ
Аюултай ачаа тээвэрлэгч тээврийн хэрэгсэлд									

9-р хүснэгт- Тэмдэг, шошгоны элемент

Ангилал		Идэмхий		Байгаль орчинд хортой			
Дэд ангилал		8.2 Арьс гэмтээгч	8.3 Нүд гэмтээгч	9.1 Усны амьд организмд хортой	9.2 Хөрсний амьд организм хортой	9.3 Сээр нуруутан амьтанд хортой	9.4 Сээр нуруугүй амьтанд хортой
Сав, баглаа боодол болон агуулах, ажлын байр	Анхааруулах тэмдэг						
	Дохио үг	Аюултай	Аюултай	Болгоомжил	Болгоомжил	Болгоомжил	Болгоомжил
	Аюулын тэмдэглэгээ	Нүд гэмтээх, арьс хүчтэй түлэх аюултай	Нүд гэмтээх, арьс хүчтэй түлэх аюултай	Усны амьтан, ургамалд маш хортой	Усны амьтан, ургамалд маш хортой	Усны амьтан, ургамалд маш хортой	Усны амьтан, ургамалд маш хортой
Аюултай ачаа тээвэрлэгч тээврийн хэрэгсэлд							

8 Тавигдах шаардлага

8.1 Анхааруулах тэмдэг

8.1.1 Анхааруулах тэмдэгт дараах шаардлагыг тавина. Үүнд:

- a) Уншихад хялбар, ойлгомжтой байна;
- b) Цаг агаарын өөрчлөлтөнд тэсвэртэй, удаанаар хадгалагддаг байна;
- c) Өнгө нь анхааруулах тэмдэг тавигдах гадаргуугийн өнгөнөөс тод ялгарахаар байна;
- d) Анхааруулах тэмдгийг өөр зураг, чимэглэл, тэмдэгтэй хамт байрлуулж болохгүй.

8.2 Шошго

8.2.1 Шошго нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- 1) Химийн бодис, бүтээгдэхүүний нэр;
- 2) Анхааруулах тэмдэг;
- 3) Дохио үг;
- 4) Аюулын тэмдэглэгээ;
- 5) Үйлдвэрлэгчээс өгөх нэмэлт мэдээлэл;
- 6) Анхны тусламж;
- 7) Үйлдвэрлэгчийн нэр, хаяг, утасны дугаар.

Бодис, бүтээгдэхүүний нэр (агууламж, томъёо)
Анхааруулах тэмдэг
Дохио үг
ЭЭ ДЭЭ Т НГЛУГГЭЭГЭГ
Үйлдвэрлэгчээс өгөх нэмэлт мэдээлэл
Анхны тусламж
Үйлдвэрлэгчийн нэр, хаяг, утас

8.3 Шошгонд дараах шаардлагыг тавина. Үүнд:

8.3.1 Химийн бодисын сав, баглаа боодол бүр заавал шошготой байх ба бат бөх бэхлэгдсэн байна;

8.3.2 Анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээ нь химийн бодисын шошгон дээр хамт байрлана. Загварыг А хавсралтад;

8.3.3 Химийн бодис нэгээс дээш ангилалд хамаарагдаж байвал ангилал бүрд хамаарах анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээг байрлуулах ба байршлыг нь зэрэглэл өндөртэйгээс эхлэн дараалуулна. Загварыг В хавсралтад;

8.3.4 Хоёр буюу түүнээс дээш сав, боодолтой химийн бодисыг савласан хайрцаг, боодол дээр бодисын нэр, НҮБ-ын дугаар (UN number) болон тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгсэл дээр тавигдах анхааруулах тэмдгийг байрлуулна. Загварыг А хавсралтад;

8.3.5 5 л эсвэл 5 кг-аас ихээр савлагдсан сав, боодол дээр бодисын нэр, НҮБ-ын дугаар (UN number), тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгсэл дээр тавигдах анхааруулах тэмдэг болон шошгыг хослуулан байрлуулна. Загварыг С хавсралтад үзүүлэв.

8.4 Химийн хорт болон аюултай бодисын шошготой хамт хор аюулын лавлах мэдээллийн дагалдах хуудас (MSDS) ба дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

8.4.1 Нэршил (химийн, техникийн болон олон улсын худалдааны нэр);

8.4.2 Олон улсын бүртгэлийн дугаар (CAS-ийн дугаар) болон НҮБ-ын дугаар;

8.4.3 Үйлдвэрлэгчийн хаяг (нэр, хаяг, утасны дугаар гэх мэт);

8.4.4 Найрлага (үндсэн бодис ба дагалдах хольц, нэмэлт бодисын концентраци);

8.4.5 Физик, химийн үндсэн ба өвөрмөц шинж чанар:

- гадаад байдал (физик төлөв, өнгө г.м);
- үнэр;
- үнэр мэдрэгдэх босго концентраци;
- рН;
- хайлах, хөлдөх температур;
- буцалж эхлэх температур, буцлах температурын хязгаар;
- шатах температур;
- ууршилтын эрчим;
- шатамхай байдал (хатуу бодис, хий);
- шатах дээд, доод хязгаар болон дэлбэрэх хязгаарууд;

- уурын даралт;
- уурын нягт;
- харьцангуй нягт;
- уусалт;
- өөрөө шатах температур.

8.4.6 Тогтвортой байдал, урвалд орох шинж

- химийн тогтвортой байдал;
- аюултай урвал явагдах боломж;
- зайлсхийх ёстой нөхцлүүд (жишээ нь, статик цэнэг, цохилт, чичиргээ г.м);
- хамт байлгаж болохгүй материалууд;
- задралаас үүсэх аюултай бүтээгдэхүүнүүд.

8.4.7 Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

- хордуулах зам (амьсгалах, арьс салстаар нэвтрэх, амаар уух гэх мэт);
- хурц ба архаг хордлого;
- богино хугацааны ба урт хугацааны үйлчлэлээс үүсэх сөрөг үр дагавар;
- хордуулах тун.

8.4.8 Байгаль орчинд үзүүлэх нөлөө

- ус, хөрс, агаар, ажлын байран дахь хүлцэх хэмжээ;
- тогтворжилт ба задрал;
- биохуримтлал;
- бусад сөрөг үр дагаварууд.

8.4.9 Аюулын тодорхойлолт

- хамаарах ангилал, зэрэглэл;
- анхааруулах тэмдэг;
- дохио үг;
- аюулын тэмдэглэгээ;
- ангилалд ороогүй бусад аюулын талаар (тэсрэлт, тоостой холбоотой аюул

гэх мэт).

8.4.10 Анхны тусламж

- яаралтай авах арга хэмжээ;
- шинж тэмдэг, шууд ба хожуу илрэх шинж тэмдэг;
- эмнэлэгийн анхны тусламж, шаардлагатай үед тусгай эмчилгээ хийх заавар.

8.4.11 Гал унтраах арга (гал унтраах хэрэгсэл, хамгаалалтын тусгай хэрэгсэл, галын аюулын үед гарах аюул: хортой хий, дэлбэрэлт);


8.4.12 Химийн бодис алдагдах үед авах арга хэмжээ (хувийн хамгаалах хэрэгсэл, онцгой нөхцөлд хийх үйлдлийн дараалал, хүрээлэн буй орчинд алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тусгаарлах, цэвэрлэх материал, аргачлал);

8.4.13 Ачиж, буулгах болон хадгалах үед анхаарах нөхцөлүүд;


8.4.14 Тухайн бодис болон хольц, хаягдлыг устгах аргачлал.

ТӨГСӨВ.

**А Хавсралт
(мэдээллийн)**



эт уллтддэлу нг лугэ

	<p>Бодис, бүтээгдэхүүний нэр (агууламж, томъёо)</p> <p><i>Дохио үг</i></p>
<p>Аюулын тэмдэглэгээ</p> <p>Шаардлагатай бол нэмэлт мэдээлэл</p> <p>Үйлдвэрлэгчийн талаарх мэдээлэл</p>	

**В Хавсралт
(мэдээллийн)**



**

Бодис, бүтээгдэхүүний нэр
(агууламж, томъёо)

Дохио үг




Аюулын тэмдэглэгээ

Шаардлагатай бол нэмэлт мэдээлэл

Үйлдвэрлэгчийн талаарх мэдээдлэл

С Хавсралт
(мэдээллийн)



Бодис, бүтээгдэхүүний нэр
(агууламж, томъёо)

Дохио үг
Аюулын тэмдэглэгээ
Шаардлагатай бол нэмэлт мэдээлэл
Үйлдвэрлэгчийн талаарх мэдэлээл

This block is enclosed in a thick black rectangular border. It contains a red diamond-shaped hazard symbol with a white skull and crossbones in the center. To the right of the symbol is the text 'Бодис, бүтээгдэхүүний нэр (агууламж, томъёо)'. Below the symbol and text are four lines of text: 'Дохио үг', 'Аюулын тэмдэглэгээ', 'Шаардлагатай бол нэмэлт мэдээлэл', and 'Үйлдвэрлэгчийн талаарх мэдэлээл'.